

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСАД ХИЙГДЭЖ БУЙ ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТҮҮД

Ш.Амангүл
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн,
Магистр, эрдэм шинжилгээний ажилтан
Email: amanqulsh@mas.ac.mn

Товч агуулга: Бүгд Найрамдах Казахстан Улс нь 1991 онд ЗХУ-аас салж, тусгаар тогтнолоо зарласан юм. Өнгөрсөн гучин жилийн хугацаанд тогтвортой хөгжлийг бий болгож, өөрчлөлт шинэчлэлтийн таатай орчинг бүрдүүлж, бүс нутаг дахь нөлөөгөө бэхжүүлэхийн зэрэгцээгээр олон улсын түвшинд идэвхтэй гадаад бодлого явуулж ирсэн орон юм. БНКаЗУ-д 2022 оны нэгдүгээр сарын хоёрноос эхэлсэн иргэдийн тайван жагсаал нь даамжирч олон нийтийг хамарсан үймээн самуун болсон нь дэлхий нийтийн гайхширлыг төрүүлсэн үйл явдал болсон. Энэхүү өгүүлэлд БНКаЗУ-д 2022 оны нэгдүгээр сарын эхний долоо хоногт болж өнгөрсөн олон нийтийг хамарсан томоохон үймээн самууны дараа тус улсад улс төр, нийгэм эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт хэрхэн явагдаж байгаа талаар өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Бүгд Найрамдах Казахстан Улс, нэгдүгээр сар, өөрчлөлт шинэчлэлт

Олон нийтийг хамарсан эсэргүүцлийн жагсаал, үймээн самууны үйл явц

Бүгд Найрамдах Казахстан Улс (БНКаЗУ) нь газарзүйн байрлалын хувьд Ази Европ хоёр тивийг дамнан оршдог, стратегийн ач холбогдол бүхий газарт байрладаг, байгалийн асар их баялаг ашигт малтмалын нөөц ихтэй, далайд гарцгүй орон юм. 1991 онд ЗХУ-аас салж, тусгаар тогтнолоо зарласанаас хойш шинээр тусгаар тогтносон улсын хувьд улс төр, нийгэм эдийн засгийн салбарт олон сорилт бэрхшээлийг даван туулан, амаргүй он жилүүдийг үдэж, туурга тусгаар, бүрэн эрхт улсаа цогцлоож, дэлхийн хамтын нийгэмлэгийн дунд эрх чөлөөтэй, цэцэглэн хөгжиж байгаа улс үндэстэн болохоо дэлхийд харуулж чадсан улс юм. БНКаЗУ нь 2.7 сая км квадрат нутаг дэвсгэртэй, нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийд эхний 9-р байранд ордог. 2021 оны байдлаар 19.2 орчим сая хүн амтай, үндэстэн угсаатны бүтцийн хувьд 130 орчим гаруй угсаатан, ястнаас бүрддэг. Дэлхийн банкны судалгаагаар, 2020 онд БНКаЗУ-ын ДНБ-ий хэмжээ 171.2 тэрбум ам. доллар буюу Төв Азийн нийт эдийн засгийн үйлдвэрлэлийн 60 хувийг эзлэж байна. Нэг хүнд ногдох GDP 9122 ам. доллар, 2013 онд эдийн засаг нь өсөлттэй байх үед GDP 14000 ам.долларт хүрч байсан байна.

БНКаЗУ-д 2022 оны нэгдүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн тус улсын Мангистау мужийн Жана-Өзен хотод шингэрүүлсэн хийн үнийн өсөлттэй холбоотойгоор иргэдийн тайван жагсаал цуглаан эхэлсэн байна. Жагсаал цуглаан нь эхний өдрүүдэд иргэдийн дунд маш тайван хэлбэрээр явагдаж байсан боловч, нэгдүгээр сарын 5-ны оройноос эхлэн үймээн самуун, бослогын шинжтэй, хурцдамал байдалтай болж ирсэн. БНКаЗУ-ын Ерөнхийлөгч жагсагчдын

шаардлагад нийцсэн зохицуулалтуудыг хүссэнээр нь шийдвэрлэсэн байна. Улмаар иргэдийн жагсаал цуглаан, эмх замбаагүй байдал, үймээн самуун болж хувирсантай холбогдуулан Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаевын зарлигаар улс орон даяар 14 хоногийн хугацаатай онц байдал тогтоосон байна.

Ерөнхийлөгчийн зүгээс шингэрүүлсэн хийн үнийг нэмэхгүй байх, нийгмийн ач холбогдолтой бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зэрэг ард иргэдэд ашигтай шийдвэр гаргаж, жагсагчидын бүх шаардлагуудыг нээлттэй хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авсан. Гэвч дараа дараагийн өдрүүдэд Алтамты, Актөбе хотуудад жагсаал өрнөж, үр дүн нь танхайрал, дээрэм, тонуулд хүргэсэн байна. Эмх замбараагүй байдал даамжирч, хотын захиргааг шатааж, нисэх онгоцны буудлыг зэргийг эзлэн авч, гадаадын зорчигч болон ачааны онгоцыг саатуулсан зэрэг халдлага үйлдсэн байна. Жагсаал цуглааныг үймээн болгож, эмх замбаагүй байдлыг өдөөн турхирсан этгээдүүд нь анхны шингэрүүлсэн гаазын хийн үнийн өсөлттэй холбоотойгоор цугларагсад биш байсан бөгөөд халдлага үйлдэгчид нь маш өндөр бэлтгэлтэй, зохион байгуулалттай бүлэглэл байсан хэмээн Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев мэдэгдсэн юм. Өөрөөр хэлбэл нийгэмд үймээн самуун эмх замбараагүй байдлыг үүсгэгчид нь урдчилан нарийн төлөвлөж, бэлтгэгдсэн терроистуудад байсныг тогтоосон байна.

БНКаЗУ-д 2021 онд “Тайван жагсаалын хууль” батлагдсан. Энэ удаагийн иргэдийн жагсаал цуглаан өрнөхөд тус хуулийн зүйл заалтуудад тусгасан иргэд тайван жагсаал хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гэсэн зарим зүйл заалтуудын дагуу иргэд талбайд гарч жагсаалыг эхлүүлэхэд хүргэсэн байна. Мөн үймээн самууны шалтгааныг судлаачид гадаад, дотоод хүчин зүйлтэй холбож үзэж, нэг хүний олон жилийн эрх мэдэл, нийгэм дэхь баян хоосны ялгаа газар авсан явдал, авлигал, ядуурлын эсрэг нийгмийн хувьсал гарлаа гэх мэт олон янзаар тайлбарласан байна. Нөгөө талаар дэлхий нийтийг хамарсан “COVID-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн улс орнууд хоорондоо хилийн хязгаарлалт хийж, улс орны эдийн засгийн нөхцөл байдал нилээдгүй сорилт бэрхшээлүүдтэй тулгарсантай холбогдуулан иргэдийн дунд ажилгүйдэл, ядуурал газар авч, иргэдийн амьжиргааны түвшин буурсан байдал нь энэхүү үймээн самууныг дэгдээх нэг хүчин зүйл болсон гэж дүгнэж үзсэн байна.

Барууны судлаачид БНКаЗУ-д болсон үйл явдал бол өнгөт хувьсгал биш бөгөөд энэ үйл явдал нь олон жил эрх барисан нэг хүний хязгааргүй эрх ямба, баялагийн хэт төвлөрөл, улс төрийн хэт хараат байдал, авлига хээл хахууль, цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл, ядуурал зэрэг хүчин зүйл нөлөөлсөн хэмээн (*Erica Marat January 05 2022*) үзсэн байна. Мөн зарим судлаачид ямар нэгэн байдлаар гаднын орнуудын төлөвлөгөө явагдаж байж болзошгүй гэж дүгнэсэн байна. Олон нийтийг хамарсан уг үймээн самуун хэт сунжирсан бол томоохон хотууд болон иргэдэд асар их хохирол учруулах тул үүссэн нөхцөл байдлыг намжаахын тулд дотоодын цэрэг, цагдаагийн байгууллагуудаас гадна Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллагын (ХАБГБ) гишүүн орнуудын энхийг сахиулагчидтай хамтран үймээнийг зогсоож чадсан байна.

Тус улсын ерөнхий прокурорын газрын мэдээлснээр уг үймээнтэй холбоотой 3666 хэрэг бүртгэгдэж, “Үймээн самуун, терроризмын үйлдэл” гэсэн заалтаар 181 хэргийг шалгасан байна. Шүүхийн шийдвэрээр 741 сэжигтнийг баривчилж, 157 хүн сэжигтэнээр татагдсан (*Азаттык Радиосы 9 наурыз 2022*) байна. Үймээний үеэр 227 хүн амь үрэгдэж, 2000 гаруй хүн шархдаж, 400 гаруй сая ам.долларын эдийн засгийн хохирол (*Азаттык Радиосы 9 наурыз 2022*) учирсан байна.

БНКаЗУ-д болж өнгөрсөн энэхүү үйл явдалтай холбогдуулан БНХАУ, ОХУ, АНУ зэрэг улсууд өөрсдийн байр сууриа илэрхийлсэн байна. Тухайлбал: БНХАУ-ын хувьд БНКаЗУ-д үүссэн нөхцөл байдал нь терроризм, салан тусгаарлах үзэл, шашны хэт даврагчдын эсрэг тэмцлээ эрчимжүүлэх шаардлагатай байгааг нотлон харууллаа хэмээн үзэж, Төв Азийн бүс нутагт анхаарлаа илүү хандуулахыг (*Азаттык Радиосы 19 кантар 2022*) уриалсан байна. БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2013 онд БНКаЗУ-д айлчлах үеэрээ “Нэг бүс-Нэг зам” санаачлагын хүрээнд тус улсад хэдэн арван тэрбум долларын хөрөнгө оруулалт хийсэн. БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосон гучин жилийн хугацаанд хоёр орны харилцаа стратегийн иж бүрэн түншлэлийн түвшинд хүрч, БНКаЗУ-ын найдвартай анд, үнэнч түнш орон юм. Гэвч нэгдүгээр сарын олон нийтийг хамарсан үймээн самууны эхний өдрүүдэд БНХАУ ямар нэгэн мэдэгдэл хийгээгүй, чимээгүй өнгөрсөн юм. Харин ХАБГБ-ын энхийг сахиулахын цэргүүд БНКаЗУ-д орж ирэх шийдвэр гарсаны дараа Бээжин мэдэгдэл хийсэн байна. БНКаЗУ-д тогтвортой байдлыг хадгалах, эдийн засгаа өргөжүүлэхэд туслалца үзүүлэхэд байгааг илэрхийлж, БНКаЗУ-тай Төв Азийн бүс нутаг дахь терроризмтой тэмцэхэд хамтран ажиллахыг уриалсан юм. Ши Жиньпин дарга БНКаЗУ-д болсон үйл явдлыг “өнгөт хувьсгал” хийх оролдлого гэж нэрлэж, ШХАБ-ын гишүүн орны хүрээнд нөхцөл байдлыг шийдвэрлэхэд БНКаЗУ-д туслухад бэлэн байгаагаа илэрхийлсэн байна. БНХАУ нь Ерөнхийлөгч К.Токаевын санааг давтаж, үймээн самууныг олон улсын террористуудын оролцоотойгоор төрийн эргэлт хийх оролдлогын үр дүн хэмээн нэрлэсэн байна. Мөн БНХАУ-аас БНКаЗУ-д суугаа Элчин сайд Жан Сяо ч нэгдүгээр сарын 12-нд "Global Times" сонинд өгсөн ярилцлагадаа, БНХАУ барууны төлөвлөж буй Исламын хэт даврагч үзэл буюу “өнгөт хувьсгал”-ыг эсэргүүцэж байна хэмээн мэдэгдэж, БНКаЗУ-д хууль сахиулах болон аюулгүй байдлын чиглэлд харилцаа хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн байна.

ОХУ-ын зарим судлаачид БНКаЗУ-д олон нийтийн жагсаал гарсан нь санамсаргүй хэрэг биш гэж (*Михаил Погребинский 2022*) үзсэн байна. Судлаач Михаил Погребинский (2022) БНКаЗУ-д болсон үймээн самуун АНУ-д зарим талаараа ашигтай, учир нь ОХУ-ын анхаарлыг Донбасаас холдуулж, ХАБГБ руу чиглүүлэх боломж олгож, ОХУ болон БНХАУ-ын харилцаанд сөрөг нөлөө үзүүлнэ хэмээн үзсэн байна.

Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев БНКаЗУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр "Эмгэнэлт нэгдүгээр сарын" үйл явдлын талаар олон нийтийн анхаарлыг татсан асуултуудад албан ёсоор хариулт өгч, БНКаЗУ-д одоогоор улс төр, нийгэм эдийн засгийн шинэчлэл хийгдэж эхэлсэнийг илэрхийлж, гуравдугаар сараас эхлэн тус шинэчлэлийг хийх талаар (*Astana times 18 February 2022*)

мэдэгдсэн байна. Тэрээр өөрчлөлт шинэчлэлтээс зайлсхийх боломжгүй, БНКаЗУ нэгдүгээр сарын эмгэнэлт үйл явдал нь манай улсад ихээхэн сургамж боллоо, цаашид улс төр, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий иргэний нийгмийг шиэнчлэхэд чиглэгдсэн *“Шинэ Казахстан руу тэмүүлэх хамтын хүчин чармайлт”* гэсэн бодлогыг хэрэгжүүлэх болно хэмээн мэдэгдсэн байна. Нэгдүгээр сарын үйл явдлалтай холбоотойгоор БНКаЗУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн улс төр нийгэм эдийн засгийн шинэчлэлийг гадаад, дотоодын зарим судлаачид дүгнэн тайлбарласан байна. Тухайлбал: БНКаЗУ Стратеги Аюулгүй байдлын хүрээлэнгийн захирал Эркин Тукумов хэлэхдээ улс төрийн шинэчлэлгүйгээр эдийн засгийг үр дүнтэй хөгжүүлэх, иргэний нийгмийг бий болгох, эцсийн дүндээ тусгаар тогтнол, тусгаар тогтнолоо хадгалах боломжгүй. Энэхүү улс төр, нийгэм эдийн засгийн шинэ шинэчлэл нь ерөнхийлөгчийн засаглал, сонгуулийн тогтолцоог өөрчлөх, улс төрийн намуудын байгуулалтыг дэмжих улс оронд ардчиллыг гүнзгийрүүлэх чухал алхам болно хэмээн үзсэн байна. Мөн БНХАУ-ын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Орос, Зүүн Европ, Төв Азийн хүрээлэнгийн захирал Сун Жуанжи хэлэхдээ, К.К.Токаевын зарласан улс төрийн шинэчлэлийг төгс эрх зүйт төр, хүчирхэг парламент, нийгмийн хамгааллын тогтолцоог сайжируулахад чиглэгдсэн хэмээн дүгнэсэн байна.

Үймээн самууны дараах улс оронд хийгдэж буй өөрчлөлт шинэчлэлүүд

Ерөнхийлөгч К.Токаев улс оронд нь болж өнгөрсөн томоохон үймээн самууны дараагаар улс төрийн томоохон томилгоонуудыг хийж эхэлсэн байна. Засгийн газрыг огцруулж, шинэ Ерөнхий сайдаар Алихан Смайловыг томилж, БНКаЗУ-ын анхны Ерөнхийлөгч Н.Назарбаевыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн (ҮАБЗ) даргын албан тушаалаас, мөн ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Карим Масимовыг мөн үүрэгт ажлаас нь чөлөөлж, эх орноосоо урвасан, төрийн эргэлт хийхийг оролдсон хэргээр баривчилсан байна.

Анхны Ерөнхийлөгч асан Назарбаев өнгөрсөн гучин жилийн хугацаанд тус улсыг ганцаараа удирдсан ч БНКаЗУ-ыг бүс нутаг хийгээд олон улсын тавцанд нэр нөлөө бүхий улс болгож, тусгаар тогтнолын эхэн үеийн амаргүй он жилүүдэд улс орноо удирдан чиглүүлж, хөгжил дэвшилд хүргэхэд тодорхой хувь нэмэрээ оруулсан гавъяатай улс төрч байсан гэж зарим ард иргэд нь түүнийг одоог хүртэл хүндлэн дээдлэх хэсэг бүлэг байгаа нь ажиглагддаг. Харин жагсаалын үеэр түүнийг дарангуйлагч, олон жил улсын хөрөнгийг хувьдаа завшсан, хэмээн эсэргүүцлээ илэрхийлж байлаа. Олон жил нэг удирдагч, нэг намын тогтцолцоотойгоор улс орныг явж ирсэн гэх асуудлууд хөндөгдөж, иргэдийн тайван жагсаал сүүлдээ элитүүдийн эсрэг тэмцэл болж хувирлаа гэх мэтээр дүгнэж, мэдээллэж байгаа нь ажиглагдаж байлаа. Түүний охид, хүргэд, тэдгээрийн хүрээллийн хүмүүсийг үүрэгт ажлуудаас чөлөөлж, эд хөрөнгийг нь хураан авч, улсын өмч болгосон байна.

Олон жил эрх барисан улс төрийн томоохон нам болох “Нур-Отан” намын нэрийг өөрчилж, Парламентын хуралдаанаар хэлэлцэж, “Аманат” хэмээх нэртэй нам болгож өөрчилсөн байна. Намын нэрийг өөрчлөх талаар Ерөнхийлөгч К.Токаев цаг үе, нийгэм, хүмүүс өөрчлөгдөхөд намын нэр солигдох нь хууль,

намын нэрийг өөрчлөх нь цаг хугацааны асуудал байсныг, нуух зүйл байхгүй гээд төрийн эрх барьж буй томоохон намын нэр бол манай улс, үндэстний хувьд онцгой ач холбогдолтой ариун нандин ойлголт байх ёстой (*Президента Республики Казахстан 1 наурыз 2022*) хэмээн мэдэгдсэн байна. Өнгөрсөн хоёрдугаар сард Парламентийн чуулганаар “Үндэслэлгүй хөрөнгөжсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай” хуулийн төслийг хэлэлцэн баталж, хоёр сарын хугацаанд 240 хүн, түүний дотор муж, бүсийн хэмжээнд 40 дарга авлигын хэрэгт холбогдсоныг тогтоожээ. Үүнд; хотын дарга нэг, бүсийн хэлтсийн дарга арван нэг, дэд сайд нэг хүн байна. Хохирлыг барагдуулахын тулд сэжигтнүүдийн 5,4 тэрбум тенгегийн хөрөнгийг (*Акорда 04 наурыз 2022*) хураан авсан байна.

Ерөнхийлөгч Касым Жомарт-Токаев гуравдугаар сарын дундуур улс оронд нь хийгдэж эхэлсэн улс төрийн шинэчлэлийн гол чиглэлүүдийн талаар ард түмэндээ хандан үг хэлэхдээ “БНКаЗУ-ын төр, эрх зүйн шинэчлэлийн чухал хэсэг нь авлигагүй шүүхийн тогтолцоо, шударга сонгуулийн төв хороо, шинэ тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой байх ёстой ” хэмээн мэдэгдсэн байна. Энэ хүрээнд нэгдүгээр сард болсон үйл явдалд эрх мэдэлтэй, өндөр албан тушаалтнуудын үндэслэлгүйгээр хөрөнгөжих явдал иргэдийг бухимдалд хүргэсэн хэмээн үзэж буйгаа илэрхийлжээ. Авлигатай тэмцэх албаны “цэвэр байдлыг” хангах үүрэг даалгаврын хэрэгжилтэд хатуу хяналт тавин ажиллахыг үүрэгдсэн байна. Энэ удаагийн (16.03.2022) түүний ард түмэндээ хандсан илгээлт нь ерөнхийдөө өнгөрсөн нэгдүгээр сард болсон үймээн самууны үйл явцаас сургамж авч цаашид дараах чиглэлд өөрчлөлт шинэчлэлтийг зайлшгүй хийх шаррдлага тулгарч байгаа мэдэгдсэн байна. Үүнд: Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн тухай, төрийн төлөөллийн салбарыг өөрчлөн байгуулах, сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох, намын тогтолцоог хөгжүүлэх боломжийг өргөжүүлэх, сонгуулийн үйл явцыг шинэчлэх, хууль сахиулах байгууллагуудыг бэхжүүлэх, хэвлэл мэдээллийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, иргэний нийгмийн институцийн үүргийг бэхжүүлэх, улс орны засаг захиргаа-нутаг дэвсгэрийн бүтцийг боловсронгуй болгох, нутгийн өөрөө удирдах ёсны төвлөрлийг сааруулах, хямралын эсрэг яаралтай арга хэмжээний авах зэрэг чиглэлд шинэчлэлүүдийг хийхээр төлөвлөсөн байна.

Дүгнэлт

БНКаЗУ-д 2022 оны нэгдүгээр сарын эхний өдрүүдэд болсон үймээн самуун үүсэхэд гадаад, дотоод олон хүчин зүйл нөлөөлсөн байна. Сүүлийн хоёр жил дараалан үргэлжилсэн дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн хүндрэл бэрхшээл, үнийн өсөлт, иргэдийн дундах ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн байдал тус үймээн самууныг үүсгэхэд нөлөөлсөн байна.

Байгалийн асар их баялагтай орон хэрнээ шингэрүүлсэн түлшний үнийг нэмэгдүүлсэн нь иргэдийн бухимдлыг хүргэж, үймээн самуун болж өрнөх нөхцөл байдлыг бий болгосон байна. Мөн нийгэм дэхь баян, ядуугийн ялгаа, эрх мэдэл, баялгийн тэгш бус хуваарилалт, шударга бус явдал газар авсантай холбогдон иргэдийн тэсвэр тэвчээр барагдаж, ард түмний дуу хоолойг сонсдог төр засаг хэрэгтэй байгааг харуулсан сургамжит үйл явдал болсон байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Erica Marat January 05 2022, "Kazakhstan's Protests Aren't a Color Revolution" <https://foreignpolicy.com/2022/01/11/kazakhstans-protests-arent-a-color-revolution/>
2. KazInform 1 наурыз 2022 "Қорғаныс министрлігі ары-бері жеңкілген әскери техника қозғалысына түсінік берді" https://www.inform.kz/kz/korganyys-ministriligi-ary-beri-zhonkilgen-askeri-tehnika-kozgalysyna-tusinik-berdi_a3906038
3. KazInform 25 ақпан 2022, "Өуе қорғанысы күштерінің мамандары біліктілігін шыңдауда" https://www.inform.kz/kz/au-e-korganyys-kushterinin-mamandary-biliktiligin-shyndauda_a3904023
4. KazInform 26 ақпан 2022, "Қазақстан мен Түркия арасындағы әскери ынтымақтастық жоспарына қол қойылды" https://www.inform.kz/kz/kazakstan-men-turkiya-arasyndagy-askeri-yntymaktastyk-zhosparyna-kol-koyldy_a3904608?fbclid=IwAR37q0AZk5BNf50IGqUH5ho_Oyl7yYU1y0h-yi9D2A8QQR5Jh1Qly2Vzcb8
5. The Astana Times, 03 March 2022 <https://astanatimes.com/2022/03/kazakhstan-sets-up-anti-crisis-team-to-address-economic-issues-stemming-from-anti-russian-sanctions/>
6. The Astana Times, 18 February 2022, "President Tokayev to Deliver Address to Nation in March, Announce Political Reforms" <https://astanatimes.com/2022/02/president-tokayev-to-deliver-address-to-nation-in-march-announce-political-reforms/?fbclid=IwAR3oKSUxxzgX0m7U7xgmGmBjbN4Oj7ykFM--uBz41JoaGBH1KYpL3Bh7SKA>
7. Азаттық Радиосы 03 науырыз 2022 "Тоқаев пен Зеленский Украина мәселесін талқылады" <https://www.azattyq.org/a/31733474.html>
8. Азаттық Радиосы 19 қантар 2022, "ҚАҢТАР ОҚИҒАСЫ" <https://www.azattyq.org/a/qantar-oqigasy-qytai-men-resei-qatynasyna-qalai-aser-etti/31660873.html>
9. Азаттық Радиосы 9 наурыз 2022 "Алматыда қаңтар оқиғасы бойынша 41 үкім шыққан. Көбіне шартты жаза тағайындалған" <https://www.azattyq.org/a/31744014.html>
10. Акорда 04 наурыз 2022, "Акорда "Мемлекет басшысы Сыбайлас жемқорлыққа қарсы іс-қимыл агенттігінің төрағасы Олжас Бектеновті қабылдады" <https://www.akorda.kz/kz/memleket-basshysy-sybaylas-zhemkorlykka-karsy-is-kimyl-agenttiginin-toragasy-olzhas-bektenovti-kabyldady-42644>
11. Михаил Погребинский 2022 "США выгодны массовые протесты в Казахстане - украинский эксперт" <https://www.ng.ru/news/729068.html>

Президента Республики Казахстан, 1 наурыз 2022 Официальный сайт "Выступление Президента Касым-Жомарта Токаева на внеочередном XXII съезде партии «Nur Otan»" <https://akorda.kz/ru/vystuplenie-prezidenta-kasym-zhomarta-tokaeva-na-vneocherednom-hhii-sezde-partii-nur-otan-12144?fbclid=IwAR3-pJuwYb0NYtJMBR5lhFuWIOQCKv60S91AxqaOaBp5T1xppJIBvn5Lsyg>